

БАТЛАВ
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ
ДАРГА Д.ЖАРГАЛСАЙХАН



МОНГОЛЫН БҮХ АРД ТҮМНИЙ СПОРТЫН ӨВЛИЙН XVI НААДМЫН НЭГДСЭН ЗААВАР

НЭГ. ЗОРИЛГО

Монгол Улсын Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь заалт, 17 дугаар зүйлийн 17.2 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2014 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 27 дугаар зарлиг, Засгийн газрын 2018 оны 183 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Улсын хэмжээний спортын наадам зохион байгуулах журам”-ын 2.1 дахь заалт, Биеийн тамир, спортын улсын хорооны (цаашид БТСУХ гэх) даргын 2022 оны А/208 дугаар тушаалын 2 дахь заалтын хэрэгжилтийг хангах, иргэдийн бие бялдрын боловсролыг дээшлүүлэх, биеийн тамир, спортын хөдөлгөөнийг өрнүүлэх, өвлийн спортын хөгжүүлэх, тамирчдын ур чадварыг нэмэгдүүлэх, тив, дэлхийн тэмцээнд өрсөлдөх өндөр зэрэглэлтэй тамирчдыг сонгон шалгаруулахад Монголын бүх ард түмний спортын өвлийн XVI наадмын (цаашид Наадам гэх) зорилго оршино.

Наадмын зорилтыг дараах хүрээнд хэрэгжүүлнэ.

1.1. Өвлийн спортоор хичээллэгсдэд спортын ажил, үйлчилгээ үзүүлэх замаар дасгал, идэвхтэй хөдөлгөөнд өргөнөөр татан оролцуулах, хичээллэх эрмэлзлийг өрнүүлэх, бие даан спортоор хичээллэх сонирхлыг төрүүлэх, нийгэмд эерэг манлайллыг бий болгох,

1.2. Иргэдийн дунд эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх, хувь хүний харьцаа хандлага, ёс зүй, соёл, тэдний сахилга хариуцлагыг сайжруулах, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх,

1.3. Биеийн тамир, спортын үйл ажиллагааг дэмжих, эрчимжүүлэх, спортын сургалтын ажлыг сайжруулах, хянах, тогтмолжуулах, наадмын тэмцээнд оролцогч тамирчид, дасгалжуулагчдын өрсөлдөх чадавхыг дээшлүүлэх,

1.4. Олимпизмын үзэл санааг дэлгэрүүлэх, олон улс, тив, дэлхийн тэмцээн, наадамд өрсөлдөх ур чадвартай тамирчдыг сонгон шалгаруулах.

1.5. Өвлийн спортыг газар зүйн байршил, орон нутгийн онцлогийг харгалзан хөгжүүлэх, оролцогчдын хамрах хүрээ, спортын төрөл, ангиллыг орон нутагт сурталчлан хөгжүүлэх,

ХОЁР. НААДМЫН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1. Наадмыг улсын хэмжээнд ерөнхий зохицуулалтаар Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хороо ханган, зааврыг сахиулан хэрэгжүүлнэ. Наадмыг зохион байгуулж буй Орхон аймагт гэрээний дагуу хамтран ажиллах, үйл ажиллагааны дэмжлэг үзүүлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч ажиллана.

2.2. Орхон аймаг нь наадмын ерөнхий зохион байгуулалтыг хариуцах ба Зохион байгуулах хороо байгуулан ажиллана. Хорооны бүрэлдэхүүнд БТСУХ, Монголын үндэсний олимпын хороо, өвлийн спортын холбоо, аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын болон бусад төлөөллийг оруулна.

2.3. Наадмын спортын төрлийн тэмцээнийг наадмын зохион байгуулах хороо, олон улсын спортын холбоодын гишүүнчлэлтэй спортын үндэсний холбоодтой хамтран зохион байгуулна.

2.4. Наадамд аймаг, дүүргийн Засаг дарга, Биеийн тамир, спортын газар, хороод, Зэвсэгт хүчин, тусгай хүчний газрын спортын хороод, их, дээд сургуулийн захиргаа нь баг тамирчдаа бэлтгэн оролцуулахыг зөвшөөрөх ба удирдлагаар хангана. Спортын нэгдсэн болон дагнасан клубүүд нь нутаг дэвсгэрийн биеийн тамир, спортын байгууллагын нэр дээр оролцоно.

2.5. Наадмын цахим бүртгэл, нэгдсэн байгууллагын дүн, веб хуудастай холбогдох үйл ажиллагааг БТСУХ-ны цахим сангийн бүртгэл болон мэдээллийн технологи хариуцсан нэгж хариуцна.

2.6. Наадмын явцын мэдээ мэдээллийг зохион байгуулах эрх олгогдсон аймаг, Зохион байгуулах хороо олон нийтэд сурталчлан мэдээлж, түгээнэ.

2.7. Наадмын спортын төрлийн тэмцээнийг өвлийн олимпын төрлийн зай ангилалд мөрдөгдөх олон улсын дүрэм, спортын холбооны тэмцээний журамд нийцүүлэн наадмын нэгдсэн зааварт тусган хэрэгжүүлнэ.

ГУРАВ. НААДМЫН ҮЕ ШАТ, СПОРТЫН ТӨРӨЛ, ХУГАЦАА

3.1 Наадмыг өвлийн олимпын наадмын хөтөлбөрт багтсан 6 спортын төрлийн зай, ангиллаар үндсэн 5, үзүүлэх тоглолтын 1 төрлөөр шууд наадамд оруулах хэлбэрээр явуулна.

3.2 Наадмын хөтөлбөрт багтсан спортын үндсэн төрөл:

3.2. 1. Гүйлтийн цана

3.2. 2. Уулын цана

3.2. 3. Гүйлтийн тэшүүр

3.2. 4. Шорт трейк

3.2. 5. Шайбтай хоккей

3.3 Наадмын үзүүлэх тоглолтын төрөлд хамаарах зай, ангилал

3.3.1 Снеүбоард / Параллель слалом, Фристайл/

3.4 Наадмын үндсэн болон үзүүлэх спортын төрлийн зай, ангилал, оролцох хүний тоо, зохиогдох хугацаа ба байршил.

3.4.1 Үндсэн төрөл:

№	Спортын төрөл	Тэмцээний зай, ангилал	Хугацаа	Байршил
1	Гүйлтийн цана	эрэгтэй: 1,5 км С, 15 км Т, 10 км С, буухиа: 2 x 6 км Т эмэгтэй: 1,5 км С, 10 км Т, 5 км С, буухиа 2 x 6 км Т буухиа баг: эрэгтэй-2, эмэгтэй-2, дасгалжуулагч-1	II/08-13	Орхон аймаг, Баян-Өндөр сум
2	Уулын цана	эрэгтэй: Слалом, Жайнт слалом, эмэгтэй: Слалом, Жайнт слалом тус бүр 2 тамирчин	II/08-13	Орхон аймаг, Баян-Өндөр сум
3	Гүйлтийн тэшүүр	эрэгтэй: 500м, 1000м, 1500м, 5000м, эмэгтэй: 500м, 1000м, 1500м, 3000м, бөөн гараа: эрэгтэй 15 тойрог, эмэгтэй 10 тойрог	II/08-13	Орхон аймаг, Баян-Өндөр сум
4	Шорт трейк	эрэгтэй: 500м, 1000м, 1500м эмэгтэй: 500м, 1000м, 1500м	II/08-13	Орхон аймаг, Баян-Өндөр сум
5	Шайбтай хоккей	эрэгтэй- баг 20 гишүүнтэй байна. 2 дасгалжуулагч, 1 эмч, Багийн бүрэлдэхүүнд 17- наснаас дээш тоглогчид байна.	II/08-13	Орхон аймаг, Баян-Өндөр сум
Тайлбар: Гүйлтийн цанын төрөлд "С" - сонгомол техник, "Т" - тэших техник Наадмын тэмцээний нарийвчилсан цагийн хуваарийг наадмын өмнө мэдээлнэ.				

4.4.2 Үзүүлэх тоглолтын төрөл

1	Снеүбоард	эрэгтэй: параллель слалом, фристайл эмэгтэй: параллель слалом, фристайл тус бүр 2 тамирчин	II/10-13	Орхон аймаг Баян-Өндөр сум
---	-----------	--	----------	-------------------------------

3.5. Наадмын үндсэн болон үзүүлэх төрлийн тэмцээн 2023 оны 2 дугаар сарын 08-13-ны өдрүүдэд Орхон аймгийн Баян-Өндөр суманд зохион явагдана.

3.6. Техникийн зөвлөгөөн: Тэмцээн зохион байгуулах хороо болон БТСУХ нь нэгдсэн зөвлөгөөнийг хийх ба Зохион байгуулах хороо ба спортын холбооны шүүгчийн зөвлөл нь тэмцээн болох газарт нь тухайн тэмцээний техникийн зөвлөгөөнийг зарлан хуралдуулж зохион байгуулна.

3.7. Тэмцээний хуваарийн дагуу зохион байгуулагдах техникийн үзүүлэлт, спортын хэрэглэл, зохион байгуулалтыг техникийн зөвлөгөөн дээр ангилал тус бүр дээр хэлэлцэнэ.

3.8. Аймаг, дүүргийн биеийн тамир, спортын газар, хороо, Зэвсэгт хүчний болон тусгай газрын спортын хороо, их, дээд сургуулийн захиргаа нь анхан шатны тэмцээнээ зохион байгуулж, тамирчдаа сонгон шалгаруулсан байна.

ДӨРӨВ. НААДАМД ОРОЛЦОГЧДОД ТАВИХ ШААРДЛАГА

4.1. Наадамд оролцогч тамирчин нь Монгол Улсын иргэн байна. Оролцогч нэг оролцогч-нэг бүртгэл шаардлагыг хангасан байна.

4.2 Оролцогч тамирчин нь аймаг, дүүргийн биеийн тамир, спортын газар, хороо, Зэвсэгт хүчний болон тусгай газрын спортын хороо, их, дээд сургуулийн аль нэг байгууллагын нэрийн өмнөөс оролцох ба харьяаллын давхардал үүсгэхгүйгээр спортын нэг төрлөө сонгон оролцоно.

4.3 Оролцогч тамирчны цахим гэрээ, мэдүүлгийн маягт илгээхээс өмнө үндсэн байгууллагын удирдлага, дасгалжуулагч нартай харилцан зөвшилцөлд хүрсний дагуу дурдсан хугацаанд хүсэлтээ илгээнэ.

4.4 Наадамд оролцох багууд нь бэлтгэлийн хувцас, спортын төрлийн хувцас, байгууллагын нэр, логотой туг далбааг барьж жагсана. Тугийн хэмжээ нь 60 см х120 см хэмжээтэй байна.

ТАВ. ЭМНЭЛЭГ ХЯНАЛТ, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА, ДААТГАЛ

5.1. Наадамд оролцох байгууллага нь өөрийн нэрийн өмнөөс оролцох баг тамирчдаа эрүүл мэндийн эмчийн үзлэгт хамруулж, үзлэгийн “зөвшөөрсөн” тэмдэглэгээг эмчийн гарын үсэг, тамгаар баталгаажуулсан бичигтэй байна.

5.2 Тэмцээнд оролцох тамирчдыг тэмцээний өдрүүдэд дэх гэнэтийн ослын болон бусад холбогдох даатгалд харьяалах байгууллагын зүгээс зайлшгүй хамруулж даатгуулна.

5.3 Аюулгүй байдлыг хамгаалах хэрэглэл, хэрэгслийг тэмцээнд оролцох тамирчдад стандартын дагуу /цана, тэшүүрийн өмсгөл, дуулга, зүсэгдэхгүй бээлий, хүзүү, толгойн хамгаалалт дуулга, шилбэний болон өвдөг, тохой, бугуй, нурууны хамгаалалт/-ыг зориулалтаар хэрэглэхийг тамирчин, хариуцсан дасгалжуулагч, багийн ахлагчаас дүрмийн дагуу шаардана.

5.4 Тэмцээн зохион байгуулагчийн аюулгүй ажиллагаа:

5.4.1 Наадмын Зохион байгуулах хороо, спортын холбоодтой хамтран тэмцээний үеийн болон бие халаалт, бэлтгэл сургуулилт, үзэгчдийн аюулгүй байдлыг бүрэн хангасан зам талбайг олон улсын дүрмийн шаардлагын дагуу зохион байгуулж, хяналт тавьж ажиллана.

5.4.2 Шүүгч болон тэмцээн зохион байгуулагч шүүгчийн зөвлөлөөс талбайн зохион байгуулалтын дагуу шаардлага тавих, биелүүлээгүй дасгалжуулагч, тамирчинд холбогдох дүрмийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

5.4.3 Ковид-19 халдварт цар тахлын цаг үеийн нөхцөл байдлаас хамаарч УОК, АОК-оос өгсөн заавар зөвлөмжийг дагаж мөрдүүлнэ.

ЗУРГАА. ЦАХИМ БҮРТГЭЛ, ЯВАГДАХ ХУГАЦАА, МАНДАТ ОЛГОЛТ

6.1. Наадмын хөтөлбөрт багтсан спортын төрөл, ангилал, зайд оролцох тамирчин тусгайлан бэлтгэсэн холбоосоор нэвтэрч өөрийн регистрийн дугаар, хувь хүний мэдээллийг ашиглахыг зөвшөөрч цахим гэрээ, мэдүүлэг бөглөн наадамд оролцох доорх хоёр сонголтоос аль нэгийг нь сонгон илгээнэ. Үүнд:

6.1.1 Нэгдүгээр сонголт: Засаг захиргааны нэгжийн (аймаг, дүүрэг) харьяаллаас оролцох бол өөрийн оршин суух хаягаар;

6.1.2 Хоёрдугаар сонголт: Зэвсэгт хүчний болон тусгай газрын спортын хороо, их, дээд сургуулийн нэрийн өмнөөс оролцох бол тухайн байгууллагын байршлын хаягаар;

6.1.3 Тамирчин дээрх сонголтуудаас аль нэгийг нь сонгон 2022 оны 12 дугаар сарын 19-ны өдрөөс 2023 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн хугацаанд Биеийн тамир, спортын улсын хороонд илгээнэ.

6.2 Аймаг, дүүргийн Биеийн тамир, спортын газар, хороодод (бусад байгууллага) 2023 оны 1 дүгээр сарын 5-6-ны өдрүүдэд цахим гэрээ, мэдүүлгийн үр дүнг Биеийн тамир, спортын улсын хорооноос ...@sport.gov.mn цахим шуудангаар хүргүүлнэ.

6.3. Нэрээр ирүүлэх мэдүүлэг

6.3.1 Наадмын хөтөлбөрт багтсан тэмцээнд оролцох баг, тамирчдын гэрээ, цахим мэдүүлгийг үндэслэн аймаг, дүүргийн биеийн тамир, спортын газар, хороо, Зэвсэгт хүчний болон тусгай газрын спортын хороо, их, дээд сургуулийн нэрээр ирүүлэх мэдүүлгийг салбарын нэгдсэн цахим сангийн бүртгэлээр дамжуулан мандатын бүртгэл хийнэ.

Цахим систем нь 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр нээж 2023 оны 01 дүгээр сарын 18-ний өдрийн 22:00 цагт хаана.

6.3.2 Наадмын хөтөлбөрт багтсан спортын төрлийн тэмцээнд оролцох баг, тамирчдын нэрээр ирүүлсэн мэдүүлгийг үндэслэн 2023 оны 01 дүгээр сарын 24-27-ны 22:00 цагийн хугацаанд оролцох баг тамирчдын QR кодтой мандатын эх файлыг аймаг, дүүргийн Биеийн тамир, спортын газар, хороодын (наадамд оролцогч бусад байгууллага) албаны цахим шуудангийн хаягаар илгээнэ.

6.3.3 Аймаг, дүүргийн Биеийн тамир, спортын газар, хороодын (наадамд оролцогч бусад байгууллага) асуудал хариуцсан нэгжээс тухайн спортын төрлөөр оролцох баг тамирчдын QR кодтой мандатын файлыг 2023 оны 01 дүгээр сарын 28-ны өдрөөс 02 дугаар сарын 06-ны өдрүүдэд засаг захиргааны нэгж дэх спортын наадамд оролцох өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн байгууллагын баг тамирчдад илгээсэн байна.

6.3.4 Наадмын хөтөлбөрт багтсан спортын төрөлд оролцох баг тамирчид наадмын мандатын ажлын хэсэгт тэмцээний хөтөлбөрт заасан техникийн зөвлөгөөнөөс өмнө мандатын баталгаажилтыг хийлгэснээр тэмцээнд оролцох эрх үүснэ.

6.3.5 Цахим бүртгэл хариуцсан аймаг, дүүргийн болон спорт холбоодын (наадамд оролцогч бусад байгууллага) админ нь наадамд оролцох дасгалжуулагч, шүүгч, албаны болон бусад чиг үүрэг гүйцэтгэн оролцох төлөөллийн бүртгэлийг тэмцээн наадмын системийн цахим бүртгэлийн хугацаанд нэгэн адилаар бүртгэж мандат олгоно.

6.4 Биеийн тамир, спортын улсын хорооны цахим бүртгэлийн асуудал хариуцсан нэгжээс баталсан цахим бүртгэлийн сургалтыг зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллана.

6.5 БТСУХ-ны цахим бүртгэлийн асуудал хариуцсан нэгж бүртгэлийн бүхий л үйл ажиллагааг хариуцаж ажиллана.

6.6 Цахим бүртгэлтэй холбоотой мэдээллийг www.sport.gov.mn цахим хуудсанд байршуулна.

ДОЛОО. НААДМЫН ХҮРЭЭНД ХИЙХ АЖЛЫН ЧИГЛЭЛ

Наадмын хүрээнд аймаг, дүүргийн биеийн тамир, спортын газар, хороо, Зэвсэгт хүчний болон тусгай газрын спортын хороо, их, дээд сургуулиуд нь дараах арга хэмжээг авч явуулна.

- Анхан шатны тэмцээн зохион байгуулах ажлын хэсгийг байгуулах, зохион байгуулах
- Наадмын анхан шатны болон шигшээ тэмцээнд оролцох төсвийг батлан гаргах
- Тухайн нутаг дэвсгэр, байгууллагын иргэдийг олноор нь хамруулсан хэлбэрээр нийтийг хамарсан тэмцээн, өвлийн спортыг сурталчилсан арга хэмжээг зохион байгуулах
- Өвлийн спортын чиглэлээр хурал, семинарыг явуулах, гарын авлага, ном, товхимол гаргах
- Тухайн нутаг дэвсгэр, байгууллагын хэмжээнд өвлийн өдөрлөг, цасны баярын спортын арга зохион байгуулах, материаллаг баазаа бэхжүүлэх, хэрэглэл материал худалдан авах, цана тэшүүрийн зам, талбай байгуулан, тохижуулах
- Өвлийн спортын төрлөөр секц нээн ажиллуулах хөдөлгөөн өрнүүлэх, алдартай тамирчдаа сурталчлах, алдаршуулах, наадмын мэдээллийн байнгын булан гарган ажиллуулах
- Наадмын шигшээ тэмцээнд амжилтай бэлтгэн, идэвхтэй оролцуулах төрөл бүрийн арга хэмжээ авах
- Олимпизмийн үзэл санааг сурталчлан, олимпын боловсрол олгох үйл ажиллагааг явуулна.

Эдгээр арга хэмжээг зохион байгуулан, хийсэн бусад ажлын тайлангаа баримтжуулан Засгийн газрын тохируулагч агентлаг – Биеийн тамир, спортын улсын хороонд ирүүлнэ.

НАЙМ. НААДМЫН СПОРТЫН ТӨРӨЛ, НАСНЫ ХЯЗГААР

8.1 ГҮЙЛТИЙН ТЭШҮҮР Зай, ангилал:

Эмэгтэй: 500м, 1000м, 1500м, 3000м, бөөн гараа

Эрэгтэй : 500м, 1000м, 1500м, 5000м, бөөн гараа

Насны ангилал: ISU-ний насны “А” ангиллын тамирчдын 2006.06.30-ны өдрөөс өмнө төрсөн байна.

8.2 ШОРТ ТРЕЙК Зай, ангилал:

Эмэгтэй : 500м, 1000м, 1500м,

Эрэгтэй : 500м, 1000м, 1500м,

Насны ангилал: ISU-ны насны "А" ангиллын тамирчдын 2006.06.30-ны өдрөөс өмнө төрсөн байна.

8.3 ГҮЙЛТИЙН ЦАНА

Зай, ангилал:

Эрэгтэй: 1,5 км С, 15 км Т, 10 км С
Эмэгтэй: 1,5 км С, 10 км Т, 5 км С,

Багийн тэмцээн- буухиа: 2 х 6 км Т эрэгтэй, эмэгтэй

Багийн бүрэлдэхүүн: эрэгтэй-2, эмэгтэй-2, дасгалжуулагч-1

Насны ангилал: 2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс өмнө төрсөн түүнээс дээш насны тамирчид оролцоно.

8.4 УУЛЫН ЦАНА

Зай, ангилал:

Эрэгтэй: Слалом, Жайнт слалом
Эмэгтэй: Слалом, Жайнт слалом

Багийн бүрэлдэхүүн: эрэгтэй 2, эмэгтэй 2, дасгалжуулагч 1

Насны ангилал: 2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс өмнө төрсөн түүнээс дээш насны тамирчид оролцоно.

8.5 ШАЙБТАЙ ХОККЕЙ

Эрэгтэй багийн бүрэлдэхүүн: 20 тоглогч, 2 дасгалжуулагч, 1 эмч байна.

Насны ангилал: 2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс өмнө төрсөн түүнээс дээш насны тамирчид оролцоно.

8.6 СНӨУБОАРД /Үзүүлэх тоглолтын төрөл/ Зай, ангилал:

Эрэгтэй: Фристайл, Параллель слалом

Эмэгтэй: Фристайл, Параллель слалом,

Багийн бүрэлдэхүүн: эрэгтэй 2, эмэгтэй 2, дасгалжуулагч 1

Насны ангилал: 2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс өмнө төрсөн түүнээс дээш насны тамирчид оролцоно.

ЕС. НААДМЫН ТӨСӨВ САНХҮҮЖИЛТ

9.1. Наадмын анхан шатны тэмцээн зохион байгуулах болон шигшээ тэмцээний хөтөлбөрт багтсан тэмцээнд оролцогчдын томилолт, хоол, байр, унааны зардлыг баг тамирчид оролцуулагч харьяалах байгууллага нь хариуцан санхүүжүүлнэ.

9.2. Баг тамирчид наадмын тэмцээнд оролцохдоо эрхийн мандатын үнэ, бусад төлбөрүүд төлөхгүй.

9.3. Наадмын зохион байгуулалтын зардал, шагнал урамшуулал болон бусад шаардагдах зардлыг наадмыг зохион байгуулах эрх хүлээн авч, гэрээ байгуулсан аймгийн Зохион байгуулах хороо хариуцна.

9.4. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 173 дугаар тогтоолын 4.4 дэх заалт “Улсын хэмжээний спортын наадам зохион байгуулах жилд тухайн насны ангиллын улсын аварга шалгаруулах тэмцээнийг улсын төсвөөс санхүүжүүлэхгүй” байх, Эрүүл мэнд, Сангийн сайдын хамтран баталсан 2009 оны 53/45 дугаар тушаалын 2.10 дахь заалт “Спортын наадмын хөтөлбөрт багтсан төрлүүдийн тухайн насны ангиллаар Улсын аварга шалгаруулах тэмцээнийг тухайн жилд давхцуулан явуулахгүй” гэсэн заалтыг аймаг, дүүргийн Биеийн тамир, спортын газар /хороо/-ууд хэрэгжүүлэн ажиллах үүрэгтэй.

АРАВ.САХИЛГА БАТ, ДЭГ ЖУРАМ

10.1 Баг тамирчид сахилга бат, ёс зүйтэй байх, спортоор дамжуулаад нийгэмд зөв хандлага, эерэг нөлөөлөл, иргэдийн идэвхтэй амьдрал эрүүл аж төрх ёсыг хэвшүүлэхэд спортын салбарын үүрэг оролцоог нэмэгдүүлэх,

10.2 Баг тамирчид нь наадмын үйл ажиллагаа, тэмцээний зам талбай гараа, бариа тогтсон байршилд, нэгдсэн зохион байгуулалтад орж үүрэг хариуцлага, хувь хүний харилцаа хандлагыг бүрэн ухамсарлаж оролцоно.

10.3 Тамирчин, дасгалжуулагч нь шударга өрсөлдөөнийг эрхэмлэнэ.

АРВАН НЭГ. ГОМДОЛ ХҮСЭЛТ

11.1. Тэмцээнд оролцох баг, тамирчид маргаантай асуудлаар тэмцээний ерөнхий шүүгчид хандан гомдол, хүсэлтээ гаргах эрхтэй.

11.2. Гомдол, хүсэлт нь үндэслэлтэй байх ёстой.

11.3. Хүсэлт, гомдлыг зөвхөн тухайн баг хариуцсан дасгалжуулагч, багийн ахлагч бичгээр өөрийн биеэр тэмцээний ерөнхий шүүгчид багийн нэр хаяг, гарын үсгийг тодорхой бичиж хандана.

11.4. Маргааныг наадмын зохион байгуулах хороо болон зохион байгуулагч спортын холбооны маргаан таслах зөвлөл асуудлыг авч шийдвэрлэнэ.

11.5. БТСУХ нь наадмын ерөнхий зохион байгуулалттай холбоотой хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэнэ.

АРВАН ХОЁР. ШАГНАЛ, УРАМШУУЛАЛ, ДҮГНЭХ ЖУРАМ

Наадмын тэмцээний төрөл зай, ангилал тус бүрд эхний гурван байр эзэлсэн баг, тамирчдыг ЗГТА-БТСУХ, наадмын ЗБХ-ноос тус бүрд нь доорх шагналаар шагнаж урамшуулна.

12.1. Тамирчин, дасгалжуулагчийг:

12.1.1. Наадмын тэмцээний үндсэн төрлийн зай, ангилалд медаль хүртсэн тамирчин, дасгалжуулагчийг наадмын медаль, өргөмжлөл, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 173 дугаар тогтоолын дагуу мөнгөн шагнал олгоно.

12.1.2 Наадмын тэмцээний үзүүлэх тоглолтын төрлийн зай, ангилалд байр эзэлсэн тамирчдыг наадмын медаль, өргөмжлөлөөр шагнана.

12.1.3 Тамирчны регистрийн дугаар, нас, овог нэр буруу, харьяаллын болон бусад зөрчил илэрсэн тохиолдолд тухайн тэмцээний амжилтыг хүчингүйд тооцон дараагийн эрэмбэлэгдсэн тамирчин, багт эзэлсэн байр, шагналыг шилжүүлнэ.

12.2 Оролцогч байгууллагыг дүгнэх

12.2.1 Наадмын өвлийн спортын төрлүүдэд авсан медалийн чанараар дүгнэнэ.

12.2.2 Засаг захиргааны нэгжийн аймаг, дүүрэг, Зэвсэгт хүчин болон тусгай хүчний газрын спортын хороод, их дээд сургуулиудыг медалийн чанараар эхний 6 байр эзлүүлж цом, медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар Зохион байгуулах хорооноос шагнаж урамшуулна.

---oOo---